



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 761

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.3.4, 6.4.3, 6.4.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ:

1. Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нөхөөгүй боловч ашиглалтын шаардлага хангахгүй, 7 нэрийн, нийт 12,262,624.00 (арван хоёр сая хоёр зуун жаран хоёр мянга зургаан зуун хорин дөрөв) төгрөгийн балансын үнэ, 11,637,678.79 (арван нэгэн сая зургаан зуун гучин долоон мянга зургаан зуун далан найман төгрөг далан есөн мөнгө) төгрөгийн хуристлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын дарга Ж.Тамирт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлжүүлэх системд”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т хүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132003066

31-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 1/дугаар сарын 16.-ны өдрийн
76 / дугаар тогтоолын хавсралт

**ТӨР, ЗАСГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГОД БҮРТГЭЛТЭЙ,
АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСАЛТ**

№	Хөрөнгийн нэр, марк	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Ашиглалтад орсон он	Нэг бурийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)	Хурумтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Аяга таваг ариутгач /Цайнд/	Ш	1	2010/12/31	199,500.00	199,500.00	199,500.00	-
2	Ус цэвэршүүлэгч Glory /том визит/	Ш	1	2011/11/02	339,000.00	339,000.00	339,000.00	-
3	Кофе буллагч SM 92	Ш	1	2020/09/28	2,508,000.00	2,508,000.00	1,883,054.79	624,945.21
4	Гал тогооны тавилга	Ш	1	2017/05/10	1,601,150.00	1,601,150.00	1,601,150.00	-
5	Ус цэвэршүүлэгч "Виникс" /440000/	Ш	2	2013/04/01	440,000.00	880,000.00	880,000.00	-
6	Кофе чанагч машин	Ш	1	2016/03/31	6,734,974.00	6,734,974.00	6,734,974.00	-
							11,637,678.79 (арван нэгэн сая зургаан зуун гучин долоон мянга зургаан зуун далан найман төгрөг далан есөн мөнгө)	624,945.21 (зургаан зуун хорин дөрөн мянга есөн зуун дочин таван төгрөг хорин нэгэн мөнгө)
							12,262,624.00 (арван хоёр сая хоёр зуун жаран хоёр мянга зургаан зуун хорин дөрөв)	12,262,624.00 (арван хоёр сая хоёр зуун жаран хоёр мянга зургаан зуун хорин дөрөв)
							7	НИЙТ ДҮН